



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2018.05.16 № 23

Асуулга тавих тухай

Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд хууль 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон билээ.

Миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд уг хуулийн хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах асуулгыг Танд тавьж байна:

1/Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаар болон хуулийг хэрэгжүүлэхэд үүсэж буй хүндрэл, бэрхшээл, хийгдэж буй ажлуудын талаар;

2/зуны улирал ойртож, усан зам нээгдэх гэж байгаатай холбогдуулан усан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар;

3/өвөл томоохон нуур, далайн ус хөлдсөний дараа хийгдэж буй мөсөн замын тээврийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар, цаашид өвлийн мөсөн замын тээврийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлого;

4/усан болон мөсөн замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой гарсан осол, зөрчлийн статистик мэдээ;


5/цаашид усан замын тээврийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, усан замын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор хийгдэх арга хэмжээний талаар болон усан замын боомтыг хөгжүүлэх асуудлаар баримталж буй бодлого;

6/усан замын тээврийн аюулгүй байдлын талаар хэрэгжиж буй эрх зүйн зохицуулалтууд буюу буй хууль, эрх зүйн акт, дүрэм журмуудын талаар.

Дээрх асуудлын хүрээнд холбогдох хуульд заасны дагуу асуулгын хариуг ирүүлнэ үү.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Л.МӨНХБААТАР

0000000033